

**ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ**

# **ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ**

**Дугаар 2012/07**

**Улаанбаатар хот  
2012 он**

**ГАРЧИГ**

	Агуулга	Хуудасны дугаар
1	Аж үйлдвэрийн салбар	2
2	Мал аж ахуйн салбар	7
3	Газар тариалангийн салбар	7
4	Цаг агаар	8

Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээг ашиглав.

## 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2012 оны эхний 7 сард 1181.9 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 97.1 тэрбум төг буюу 9.0 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 2012 оны эхний 7 сард 2295.2 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 394.2 тэрбум төг буюу 15.2 хувиар өссөн.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2012 оны эхний 7 сард оны үнээр 3228.0 тэрбум төг болж, үүний 2077.5 тэрбум төг буюу 64.4 хувийг гадаад зах зээлд борлуулжээ.

## Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн, салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая төг

Аж үйлдвэрийн салбар	2011 <sup>VII</sup>	2012 <sup>VII</sup>	2011 <sup>I-VII</sup>	2012 <sup>I-VII</sup>	$\frac{2012^{I-VII}}{2011^{I-VII}}$ (%)
<b>Аж үйлдвэрлийн нийт бүтээгдэхүүн, 2005 оны зэрэгцүүлэх үнээр</b>	<b>147597.9</b>	<b>162946.9</b>	<b>1084793.9</b>	<b>1181924.5</b>	<b>109.0</b>
<b>Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн</b>	<b>51909.6</b>	<b>57119.3</b>	<b>326319.3</b>	<b>350720.5</b>	<b>107.5</b>
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	24971.2	28499.0	164796.8	181708.6	110.3
Тамхи үйлдвэрлэл	1114.3	804.4	11868.1	11331.5	95.5
Нэхмэлийн үйлдвэрлэл	11112.3	7118.6	64433.1	44014.6	68.3
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	286.5	153.8	3835.9	3135.4	81.7
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	30.0	451.9	1368.0	3114.9	227.7
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	176.6	238.8	1169.4	1380.5	118.1

Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	240.8	377.4	1375.4	2482.6	180.5
Тавилга үйлдвэрлэл, бусад	70.5	329.3	578.0	2211.9	382.7

**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн, салбараар, оны үнээр, сая төг**

<i>Аж үйлдвэрийн салбар</i>	<i>2011<sup>VII</sup></i>	<i>2012<sup>VII</sup></i>	<i>2011<sup>I-VII</sup></i>	<i>2012<sup>I-VII</sup></i>	<i>Үүнээс: гадаадад</i>
<b>Аж үйлдвэр, бүгд</b>	<b>412779.7</b>	<b>353641.2</b>	<b>2804076.3</b>	<b>3227978.1</b>	<b>2077514.8</b>
<b>Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн</b>	<b>103248.3</b>	<b>142135.0</b>	<b>625543.4</b>	<b>1043721.7</b>	<b>374620.2</b>
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	62182.5	77459.3	339002.5	423020.0	2814.4
Тамхи үйлдвэрлэл	4467.7	3825.6	24567.7	24283.9	-
Нэхмэлийн үйлдвэрлэл	15502.1	12624.5	101062.1	85122.4	54863.4
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	729.4	677.3	5592.9	4968.7	-
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	101.0	257.2	1448.8	1683.0	699.4
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	427.6	1454.0	4423.7	6630.6	-
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1077.0	1790.6	6181.2	8804.9	-
Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	237.9	222.1	821.8	1164.9	3.2

## Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

Бүтээгдэхүүн	хэм. нэгж	2011 <sup>VII</sup>	2012 <sup>VII</sup>	2011 <sup>I-VII</sup>	2012 <sup>I-VII</sup>	$\frac{2012^{I-VII}}{2011^{I-VII}}$ (%)
Хивс	мян.м2	52.8	35.9	454.4	465.2	102.4
Сүлжмэл эдлэл	мян.ш	69.4	86.2	396.3	411.3	103.8
Самнасан ноолуур	тн	131.2	42.6	687.9	228.2	33.2
Эсгий	мян.м	24.2	9.9	109.1	129.0	118.2
Тэмээний ноосон хөнжил	мян.м	0.4	-	12.1	2.6	21.5
Эсгий гутал	мян.хос	0.6	1.1	19.9	15.5	77.8
Нэхий дээл	ш	522	-	8317	3051	36.7
Савхин гутал, ботинк	мян.хос	0.6	0.4	3.4	6.8	197.7
Барилгын модон хаалга, цонх	м2	667.9	456.2	4149.0	3730.1	89.9
Барилгын шалны банз	м3	-	81.4	148.0	898.7	607.2
Зүсмэл материал	м3	440.1	3482.0	3481.1	5930.0	170.3
Дэвтэр	мян.ш	685.0	2087.0	4128.8	5884.8	142.5
Ариун цэврийн цаас	мян.ш	398.7	379.2	1374.3	2729.5	198.6
Бичгийн цаас	тн	2.8	11.5	119.3	90.2	75.6
Сонин	сая.х.д.х	3.2	3.6	22.4	33.5	149.9
Ном	сая.х.д.х	4.3	3.7	24.7	29.9	121.0
Шахмал түлш	тн	10.5	-	780.9	4129.5	528.8
Гоо сайхны тос	мян.ш	8.4	45.2	326.0	420.5	129.0
Вакуум цонх, хаалга	м2	1133.1	1149.0	4451.0	4117.7	92.5

## Хүнсний салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	хэм. нэгж	2011 <sup>VII</sup>	2012 <sup>VII</sup>	2011 <sup>I-VII</sup>	2012 <sup>I-VII</sup>	$\frac{2012^{I-VII}}{2011^{I-VII}}$ (%)
Үхрийн мах	тн	0.5	-	191.6	459.1	239.6
Хонины мах	тн	-	-	233.9	415.0	177.4
Адууны мах	тн	-	-	57.3	16.8	29.3
Ямааны мах	тн			59.7	300.0	502.5
Гахайн мах	тн	1.7	2.0	11.5	12.0	104.3
Өлөн гэдэс	мян.гогцоо	123.1	13.0	516.4	545.2	105.6
Хиамны зүйл	тн	140.3	225.7	1150.6	1190.8	103.5
Боловсруулсан шингэн сүү	мян.л	1349.3	1404.7	12282.3	14644.5	119.2
Тараг	мян.л	907.1	518.1	5279.3	4831.3	91.5
Цөцгий, цөцгийн тос	тн	60.5	118.1	509.8	945.3	185.4
Аарц, бяслаг	тн	5.1	27.7	32.0	178.3	557.2
Дээд гурил	тн	2100.9	230.5	13726.7	4705.2	34.2
Нэгдүгээр гурил	тн	2848.9	4891.1	37468.5	29969.3	80.0
Хоёрдугаар гурил	тн	385.8	773.9	6460.5	8653.8	133.9
Нарийн боов	тн	1125.4	1116.8	7029.7	7646.7	108.8
Бялуу	тн	48.3	57.1	301.3	473.3	157.1
Чихэр	тн	4.9	8.4	48.9	56.5	115.5
Талх	тн	1945.0	1939.3	12231.6	14060.4	115.0
Гоймон	тн	211.6	4.9	1184.5	461.0	38.9
Спирт	мян.л	178.4	153.7	2042.3	2192.6	107.4
Архи	мян.л	2255.5	2586.1	15127.1	15577.3	103.0
Дарс	мян.л	4.8	3.6	78.8	47.4	60.2
Шар айраг	мян.л	4413.1	6366.5	31251.4	38602.6	123.5
Цэвэр ус	мян.л	3951.1	3165.8	16956.6	20140.6	118.8
Амтат ус, ундаа	мян.л	9036.9	8867.6	40287.4	45723.7	113.5
Жүүс	мян.л	5700.1	7256.5	29199.9	37305.6	127.8

## Экспортын гол нэрийн бараа

Бараа	хэм.нэгж	2011 <sup>I-VII</sup>	2012 <sup>I-VII</sup>	$\frac{2012^{I-VII}}{2011^{I-VII}} \%$
Үхрийн хөлдүү мах	т	2549.3	-	-
Адууны мах	т	91.8	250.1	272.6
Малын дайвар бүтээгдэхүүн	т	262.9	819.7	311.8
Шеврет	сая дм <sup>2</sup>	213.7	90.7	42.4
Шевро	сая дм <sup>2</sup>	107.4	32.0	29.7
Адууны шир	мян.ш	133.0	77.2	58.0
Хонины самнаагүй ноос	т	5298.8	1864.1	35.2
Бохир ноолуур	т	2301.3	2982.0	129.6
Самнасан ноолуур	т	210.1	250.0	119.0
Свитер, пуловер, джемпер, жилет болон сүлжмэл гадуур цамц	мян.ш	66.5	32.6	49.0

## Импортын гол нэрийн бараа

Бараа	хэм.нэгж	2011 <sup>I-VII</sup>	2012 <sup>I-VII</sup>	$\frac{2012^{I-VII}}{2011^{I-VII}} \%$
Өндөг	мян.ш	37816.3	48520.1	128.3
Төмс	т	5365.4	2992.9	55.8
Сонгино, сармис	т	8976.5	5288.8	58.9
Алим, лийр	т	4420.6	1551.4	35.1
Ногоон цай	т	1490.8	1062.0	71.2
Цагаан будаа	т	5576.8	20995.1	376.5
Шар будаа	т	824.4	891.3	108.1
Гурил	мян.т	41.6	40.8	98.1
Ургамлын тос	т	2728.7	4215.1	154.5
Элсэн чихэр	т	23350.5	24477.0	104.8
Хатуу чихэр	т	3019.9	3181.2	105.3
Согтууруулах биш ундаа	мян.л	11599.7	11957.8	103.1
Согтууруулах ундаа	мян.л	11973.8	16616.5	138.8
Үүнээс: Шар айраг	мян.л	10951.6	15673.5	143.1
Янжуур	сая.ш	1001.2	1203.9	120.2

## 2. МАЛ АЖ АХУЙН САЛБАР

Өнгөрсөн оны эцсийн байдлаар Улсын хэмжээнд 36.3 сая мал тоологдсон бөгөөд энэ оны эхний 7 сарын байдлаар 275.6 мянган мал зүй бусаар хорогдсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 45.6 хувиар буурав. Мөн 2012 оны эхэнд тоологдсон нийт хээлтэгчийн 86.2 хувь нь төллөж, гарсан төлийн 98.4 хувь буюу 13.3 сая төл бойжиж байна.

## 3. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАР

Энэ онд 306,1 мянган га талбайд үр тариа, 16,1 мянган га талбайд төмс, 7,0 мянган га талбайд хүнсний ногоо, 32,3 мянган га талбайд тосны ургамал, 10,0 мянган га талбайд тэжээл тариалсан.

Ургацын урьдчилсан баланс гараагүй байгаа ч тооцож байгаагаар буудай 450,0 мянган тонн, төмс 200,0 мянган тонн, хүнсний ногоо 90,0 мянган тонн, тосны ургамал 20,0 мянган тонн, ногоон тэжээл 35,0 мянган тонноос доошгүйг тус тус хураан авах боломжтой байна.

Ургац хураалтын техникийн бэлэн байдал 85 хувьтай байна. Ургац хураалтад үр тариа хураах комбайн 1200 гаруй ажиллана.

ТЭДСангийн элеваторуудад өнгөрсөн оны борлуулагдаагүй буудай хадгалагдаж байгаа учраас энэ онд авлагадаа авах 113,848 тонн буудайн 36,000 тонн буудайг өөрийн элеваторт үлдэх хэсгийг түрээсийн агуулахад, гурилын үйлдвэрүүд 135,000 тонн, архи спиртийн үйлдвэрүүд 7,500 тонныг тус тус хүлээн авч үр тарианы аж ахуйнуудын агуулахад 202,000 тонн буудай хадгална.

Улсын хэмжээнд энэ онд 302,200 тонн төмс, хүнсний ногооны ургац хураан авна. Нийт ургацын 30-35 хувь буюу 90,000-120,000 тонныг намрын улиралд худалдан борлуулахаар тооцоход 13,000 тонн төмс, хүнсний ногоо хадгалах зорь дутагдах хүндрэл үүсэхээр байна.



## 4.ЦАГ АГААР

2012 оны 9 дүгээр сарын цаг агаарын урьдчилсан мэдээ \*\*

### УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

Есдүгээр сарын агаарын дундаж температур Их нууруудын хотгор, Алтайн өвөр говь болон говийн нутгийн өмнөд хэсгээр 14-19, Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 8-13, бусад нутгаар 4-9 градус дулаан байдаг. Гэвч 1957, 1968, 1970, 1985, 2011 онд ихэнх нутгаар, 1989, 1990, 1997 онд нутгийн зүүн хэсгээр, 1992, 1994 онд нутгийн баруун хэсгээр 1.5-3.5 градусаар хүйтэн байсан бол 1966, 1973, 1977, 1978, 1988 онд ихэнх нутгаар олон жилийн дунджаас 1.5-2.5 градусаар, 1998, 2000-2002, 2007 онд 2.5-5.7 градусаар дулаан байжээ. Зарим жилд агаарын үнэмлэхүй их температур зүүн ба говийн нутгаар 30-35, бусад нутгаар 24-29 градус хүрч дулаардаг бол үнэмлэхүй бага температур говийн нутгаар 4-9, бусад нутгаар 8-14 градус хүрч хүйтэрдэг байна.

Энэ сард ордог хур тунадасны хэмжээ наймдугаар сарынхтай харьцуулахад эрс багасч баруун ба говийн ихэнх нутгаар 4-9, харин баруун зүгийн нутгийн зүүн хойд хэсэг болон төв ба зүүн зүгийн ихэнх нутгаар 20-30, зөвхөн Хөвсгөл, Хэнтий, Дорнодын хойд, Булганы зүүн, Сэлэнгийн баруун хэсгээр 32-43, бусад нутгаар 10-20 мм ордог. Гэвч зарим жил үүнээс нилээд хэлбэлзэлтэй байдаг. Тухайлбал: 1973, 1975, 1984, 1987, 1991, 1994, 1999 онд ихэнх нутгаар, 2010 онд говийн нутгаар олон жилийн дунджаас их хур тунадас орсон бол 1965-1967, 1978, 1980, 1995, 1996, 2000, 2002, 2006 онд харьцангуй бага хур тунадас орж байжээ.

Салхи 15 м/с-ээс ихсэх тохиолдол баруун зүгийн нутгаар 5 удаа, бусад нутгаар 2-4 удаа ажиглагддаг бөгөөд говийн нутгаар 2-3 удаа шороон шуурга, бусад нутгаар 1-2 удаа цасан ба шороон шуурга шуурдаг. Сүүлийн жилүүдийн мэдээгээр 1980 онд Хэнтий, Сүхбаатар аймгийн нутгаар салхи 20-24 м/с хүрч хүчтэй шороон шуурга шуурч байв..

### ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

**Баруун зүгийн нутаг.** Агаарын температурын сарын дундаж нь Алтай, Хангайн уулархаг нутгаар 4-9, Алтай өвөр говиор 14-19, бусад нутгаар 9-14 градус дулаан буюу Их нууруудын хотгороор олон жилийн дунджаас 0.5 градусаар дулаан, бусад нутгаар дунджийн орчим байна.

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхний хагаст Хангайн уулархаг нутгаар шөнөдөө 0-5 градус хүйтэн, өдөртөө 12-17 градус дулаан, Их нууруудын хотгор, Алтайн өвөр говиор шөнөдөө 11-16, өдөртөө 23-28 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 3-8, өдөртөө 18-23 градус дулаан байна. Харин нэгдүгээр арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар сэрүүснэ. Хоёр ба гуравдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр хүйтэрч Алтай, Хангайн уулархаг нутгаар шөнөдөө 8-13 градус хүйтэн, өдөртөө 3-8 градус дулаан,

Алтайн өвөр говиор шөнөдөө 5-10, өдөртөө 15-20 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 1 градус дулаанаас 4 градус хүйтэн цочир хүйтрэх ба өдөртөө 6-11 градус дулаан байна. Бусад хугацаанд Хангайн уулархаг нутгаар шөнөдөө 5-10 градус хүйтэн, өдөртөө 7-12 градус дулаан, Алтайн өвөр говиор шөнөдөө 9-14, өдөртөө 20-25 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 0-5, хөрсөн дээр цочир хүйтэрнэ, өдөртөө 13-18 градус дулаан байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Баян-Өлгийн өмнөд, Увсын хойд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, Баян-Өлгийн хойд, Завханы зүүн, Баянхонгорын өмнөд хэсэг, Ховд, Говь-Алтайн ихэнх нутгаар олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим байна.

Нэгдүгээр арав хоногийн эхээр нутгийн хойд хэсгээр, дунд үеэр нь ихэнх нутгаар бороо, уулархаг нутгаар хур тунадас орно. Хоёр ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар, гуравдугаар арав хоногийн эхээр нутгийн зарим газраар хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орно.

Салхи нэгдүгээр арав хоногийн дунд үеэр зарим газраар түр зуур 14-16 м/с хүрч ширүүснэ. Харин хоёрдугаар арав хоногийн дунд үе болон сүүлч, гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр нутгийн өмнөд хагаст 18-20 м/с хүртэл ширүүсч шороон шуурга шуурах төлөвтэй.

**Төвийн нутаг.** Агаарын температурын сарын дундаж нь нутгийн баруун хэсгээр 4-9, бусад нутгаар 9-14 градус дулаан ба ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байна.

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхээр Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар шөнөдөө 3 градус дулаанаас 2 градус хүйтэн, өдөртөө 15-20 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 5-10, өдөртөө 23-28 градус дулаан байна. Харин нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн дунд үе болон эцсээр сэрүүсч Дархадын хотгор болон Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар шөнөдөө 2-7 градус хүйтэн, өдөртөө 5-10 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 3 градус дулаанаас 2 градус хүйтэн, цочир хүйтрэх ба өдөртөө 8-13 градус дулаан байна. Гуравдугаар арав хоногийн дунд үе ба эцсээр хүйтэрч Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар шөнөдөө 5-10 градус хүйтэн өдөртөө 0-5 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 0-5 градус хүйтэн, өдөртөө 5-10 градус дулаан байна. Бусад хугацаанд Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар шөнөдөө 1-6 градус хүйтэн, өдөртөө 12-17 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 1-6, өдөртөө 17-22 градус дулаан байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Хөвсгөлийн зүүн, Булганы баруун, Архангайн хойд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, Хөвсгөл, Архангайн баруун өмнөд, Өвөрхангайн зүүн хойд, Төв аймгийн өмнөд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим байна.

Нэгдүгээр арав хоногийн дунд үеэр зарим газраар, нэгдүгээр арав хоногийн эцэс, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр их төлөв бороо, уулархаг нутгаар хур тунадас

орно. Харин хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үе ба сүүлчээр ихэнх нутгаар хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орох төлөвтэй. Энэ үеүдэд салхи нутгийн өмнөд хэсгээр 12-14 м/с, ялангуяа хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үе ба эцсээр зарим газраар 16-18 м/с хүртэл ширүүсч шороон шуурга шуурах төлөвтэй.

**Зүүн зүгийн нутаг.** Агаарын температурын сарын дундаж нь бүх нутгаар 8-13 градус дулаан буюу Дорнод, Сүхбаатарын өмнөд хэсгээр олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар сэрүүн, бусад нутгаар дунджийн орчим байна.

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхний хагаст шөнөдөө нутгийн хойд хэсгээр 3-8, бусад нутгаар 7-12, өдөртөө ихэнх нутгаар 23-28 градус дулаан байна. Харин нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн дунд үе болон эцсээр сэрүүсч Хэнтэйн уулархаг нутгаар шөнөдөө 0-5 градус хүйтэн цочир хүйтрэх ба өдөртөө 7-12 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 1-6, өдөртөө 11-16 градус дулаан байна. Гуравдугаар арав хоногийн дунд үе ба сүүлчээр шөнөдөө нутгийн хойд хэсгээр 4-9 градус хүйтэн, өдөртөө 1-6 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 2 градус дулаанаас 3 градус хүйтэн цочир хүйтэрнэ, өдөртөө 6-11 градус дулаан байна. Бусад хугацаанд нутгийн хойд хэсгээр шөнөдөө 4 градус дулаанаас 1 градус хүйтэн, өдөртөө 13-18 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 3-8, өдөртөө 17-22 градус дулаан байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Дорнодын зүүн хойд, Сүхбаатарын өмнөд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, Хэнтийн өмнөд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим байна.

Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр зарим газраар дуу цахилгаантай бороо орно. Харин хоёрдугаар арав хоногийн сүүлчээр ихэнх нутгаар, гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр нутгийн зарим газраар хур тунадас, Хэнтэйн уулархаг нутгаар нойтон цас орох төлөвтэй. Дээрх үеүдэд ихэнх нутгаар салхи 12-14 м/с хүрч ширүүсэх ба ялангуяа нэг ба хоёрдугаар арав хоногийн дунд үе ба сүүлч, гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр зарим газраар 18-20 м/с хүрч ширүүсэн шороон шуурга шуурах төлөвтэй.

**Говийн нутаг.** Агаарын температурын сарын дундаж нь нутгийн өмнөд хэсгээр 14-19, бусад нутгаар 8-13 градус дулаан буюу ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байна. Нэгдүгээр арав хоногийн ихэнх хугацаанд болон хоёрдугаар арав хоногийн эхний хагаст ихэнх нутгаар шөнөдөө 10-15, өдөртөө 24-29 градус дулаан байна. Харин нэгдүгээр арав хоногийн дунд үеэр сэрүүсч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 0-5 градус дулаан, хөрсөн дээр хасах 2 градус хүрч сулхан цочир хүйтрэх төлөвтэй, өдөртөө 10-15 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 3-8, өдөртөө 14-19 градус дулаан байна. Хоёрдугаар арав хоногийн сүүлч болон гуравдугаар арав хоногийн дунд үе болон эцсээр эрс сэрүүсч Дундговийн нутгаар шөнөдөө 2 градус дулаанаас 3 градус хүйтэн, цочир хүйтрэх ба өдөртөө 5-10 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 1-6, өдөртөө 10-15 градус дулаан байна. Бусад хугацаанд ихэнх

нутгаар шөнөдөө 6-11, өдөртөө 18-23 градус дулаан байна.

Энэ сард Дундговь, Дорноговь, Говь-Сүмбэрийн ихэнх нутгаар олон жилийн дунджаас бага, Өмнөговийн ихэнх нутгаар олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орно.

Нэгдүгээр арав хоногийн дунд үеэр зарим газраар бороо орно. Дуу цахилгаантай. Харин хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн эхээр зарим газраар, сарын эцсээр нутгийн зүүн хэсгээр хур тунадас орох төлөвтэй.

Салхи нэг ба хоёрдугаар арав хоногийн дунд үе ба сүүлч, гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үе, мөн сарын эцсээр зарим нутгаар 18-20 м/с хүртэл ширүүсч шороон шуурга шуурах төлөвтэй.

*\*\* - Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар, Ус, цаг уурын хүрээлэн*